

## ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГТ COVID-19 ҮЗҮҮЛЖ БАЙГАА НӨЛӨӨЛӨЛ БОЛОН SARS (2003), 2008-2009 ОНЫ ХЯМРАЛТАЙ ХАРЬЦУУЛАХ НЬ

А.Энхбат\*, Б.Мэнд-Амар\*\*

**Хураангуй:** Коронавирусын халдвар буюу COVID-19 цар тахал дэлхий нийтэд эрчимтэй тархаж байгаагаас үүдэн эдийн засгийн системд томоохон доголдол гарч, олон улсыг хамарсан санхүүгийн гүн хямрал нүүрлэж эхлээд байна. Иймээс энэхүү хямралын хор хохирлыг аль болох бага хэмжээнд барих, түүнийг түргэн хугацаанд даван туулах арга замын олохын тулд тус өвчний үеийн эдийн засгийн нөхцөл байдлыг SARS өвчин болон 2008-2009 оны үеийн эдийн засгийн хямрал (Дэлхийн санхүүгийн хямрал)-тай харьцуулсан судалгааг хийж, түүн дээр үндэслэн COVID-19 өвчний үеийн эдийн засгийн хямралын хэмжээг тодорхойлж, цаашдын өрнөлийг урьдчилан таамаглахыг зорив.

**Түлхүүр үгс:** Дэлхийн санхүүгийн хямрал, КОВИД -19, Их хямрал, Эдийн засгийн хямралын үеийн туршлага, Хямралаас гарахад хэрэгжүүлсэн арга хэмжээ

## IMPACT OF COVID-19 ON THE WORLD ECONOMY AND ITS COMPARISON WITH SARS (2003) AND GLOBAL FINANCIAL CRISIS (2008, 2009)

**Abstract:** As the coronavirus pandemic (COVID-19) spreads around the world, it impacted on the global economic system and causing the international financial crisis. Therefore, it is important us to predict its future developments and find a way to defeat it in the soonest possible time. For this purpose, we have conducted the research on the economic situation during COVID-19 and compare it with the situation during SARS and Global Financial Crises to determine the extent of the crisis and its possible solutions.

**Keywords:** Global financial crisis, COVID – 19, Great Depression, Experience of economic crisis, Measures taken to overcome the crisis

---

\* МУИС-ийн Бизнесийн сургууль, (E-mail): enkhbatamarjargal@gmail.com

\*\* МУИС-ийн Бизнесийн сургууль (E-mail): mend-amar@hotmail.com

**Зорилго:**

COVID-19 цар тахлаас үүдэлтэй дэлхийн эдийн засгийн хямралыг SARS өвчин болон Дэлхийн санхүүгийн хямралтай харьцуулан судалж, шинээр гарч буй эдийн засгийн хямралын хохирлын хэмжээ, хохирлыг бага байлгах талаар авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээг өмнөх туршлага дээр үндэслэн тодорхойлоход энэхүү судалгааны зоригло оршино оршиж байна.

**Зорилт:**

Энэхүү судалгааны ажлын дээрхи зорилгын хүрээнд дараахь зорилтуудыг тавьж судалгаа хийсэн болно. Үүнд:

- COVID-19, SARS өвчин болон Дэлхийн санхүүгийн хямралын өмнөх үеийн эдийн засгийн нөхцөл байдлыг харьцуулан судлах,
- Эдгээр хямралын үед үүссэн эдийн засгийн хүндрэл, бэрхшээлийг харьцуулж, COVID-19-өөс үүдэн гарах хор хохирлын хэмжээг урьдчилан тодорхойлох,
- Өмнө болж байсан эдийн засгийн хямралуудын туршлага дээр тулгуурлан COVID-19-өөс үүдэн гарах хор хохирлын хэмжээг бууруулах, урьдчилан сэргийлэх чиглэлээр цаашид авах шаардлагатай зөвлөмжийг боловсруулах зэрэг болно.

**Судалгааны аргачлал:**

SARS, Дэлхийнсанхүүгийн хямрал, COVID-19 өвчний эдийн засагт үзүүлсэн нөлөөллийг судлахдаа хямралд хамгийн ихээр өртсөн орнууд (АНУ, Хятад, Испани, Итали, Франц, Герман, Их Британи, ОХУ)-ын макро эдийн засгийн голлох үзүүлэлтүүдийг хямралын эхлэх үе болон дараах үеийн үзүүлэлттэй нь харьцуулах аргыг сонгов. Энэхүү судалгаанд орсон тоон мэдээллүүдийг цуглуулахдаа дэлхийн банк болон тухайн орнуудын Засгийн газрын албан ёсны эх сурвалжийг ашиглахыг зорив.

Харин COVID-19 өвчний үеийн эдийн засгийн судалгааны тухайд 2020 оны эхний улирлын тоон мэдээллүүд бүрэн гараагүй, 2019 оны 1 дүгээр улирлын тоо мэдээллүүд дутмаг олдож байсан нь тодорхой бэрхшээлүүдийг учруулж байгаа юм. Иймээс COVID-19 өвчний гарсан эхний 3 сарын хугацаан дахь эдийн засгийн уналтын эрчмийг бусад хямралын мөн хугацааны эрчимтэй харьцуулан үзэх замаар судалгааг хийхээр төлөвлөсөн бөгөөд энэ нь богино хугацааг хамарч байгаа тул судалгааны үр дүнд сөргөөр нөлөөлөх боломжтой гэдгийг тооцож үзсэн болно.

**Оршил:**

Шинэ төрлийн коронавирус буюу COVID-19 өвчин 2019 оны 12 дугаар сард БНХАУ-ын Ухань хотод анх бүртгэгдсэн бөгөөд 2020 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар 4 сая 53 мянга гаруй хүн халдварлаж, түүний улмаас 279 мянга гаруй хүн нь нас бараад байна. Нийт халдвар авсан хүмүүсийн ихэнх нь АНУ,


Испани, Итали, Их Британи, ОХУ, Франц, Герман, БНХАУ зэрэг дэлхийн эдийн засаг, аж үйлдвэр, санхүүд чухал байр суурь эзэлдэг орнуудад илэрсэн нь дэлхийн эдийн засгийн системд хүчтэй нөлөө үзүүлэх үндсэн шалтгаан болсон гэж үзэж байна. Одоогоор вирусн халдварын вакцин эвсэл өвчнийг баталгаатай эдгээдэг эм бэлдмэл хараахан гараагүй байгаа бөгөөд нөхцөл байдал цаашид энэ чигээр удаан үргэлжилбэл дэлхийн эдийн засаг, санхүүгийн системд урьд өмнө үзэгдэж байгаагүй том хэмжээний хямрал бий болгох үндсэн шинж тэмдгүүд гарч эхэлсэн байна.

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD)-ын тооцоолсноор COVID-19-ийн дэгдэлт дэлхий нийтийн үйлдвэрлэл, худалдаа, аялал жуулчлалын салбар хамгийн ихээр сөрөг нөлөөллийг үзүүлж байгаа бөгөөд дэлхийн эдийн засгийн өсөлт 2020 онд 1 хувь буюу түүнээс ч бага түвшинд хүрч буурах хандлагатай байгааг тус байгууллагаас анхааруулжээ.

### Нэг. Дэлхийн эдийн засагт SARS-ийн үзүүлсэн нөлөөлөл

БНХАУ-ын Гуандун мужид 2002 оны 11 дүгээр сард анх бүртгэгдсэн SARS өвчний халдвар дэлхийн дэлхийн 29 улс, газар нутагт тархаж нийт 8096 хүн халдвар авсны 774 нь амь насаа алдсан байна. Тус өвчний голомт нь БНХАУ байсан бөгөөд Хонг Конг, Тайван, Канад, Сингапурт өвчин эрчимтэй тархаж байв. Тус өвчний улмаас БНХАУ, Хонг Конг хамгийн ихээр эдийн засгийн хохирол амссан бөгөөд 2003 оны байдлаар Хонг Конг ДНБ-нийхээ 2.63 хувь, БНХАУ ДНБ-нийхээ 1.05 хувийг тус тус алдсан гэж тооцоолжээ. [1]

*Зураг 1. SARS –ын үеийн ДНБ-ний өсөлтийн хурд (сонгогдсон орнууд)*




Эх сурвалж: <https://data.worldbank.org/indicator/ny.gdp.mktp.kd.zg>

Дээрх хүснэгтээс үзэхэд SARS-ийн үеэр Их Британи, ОХУ-ын өсөлт буурсан, БНХАУ-ын өсөлт саарсныг эс тооцвол дэлхийн хэмжээнд эдийн засгийн томоохон хямрал нүүрлэсэн шинж тэмдэг илэрсэнгүй. Харин SARS өвчний дараа буюу 2005

онд Герман, ОХУ, АНУ-ын ДНБ-ны өсөлт саарч байгаа нь тус өвчний дам нөлөө эвсэл эдийн засгийн мөчлөгтэй холбоотой бууралт байж болзошгүй гэж үзэж байна.


**Зураг 2. SARS –ын үеийн Гадаад худалдааны эргэлт (ДНБ-нд эзлэх хувь)**



Эх сурвалж: <https://data.worldbank.org/indicator/ne.trd.gnfs.zs>

SARS-ын үеэр дэлхийн голлох эдийн засагтай орнуудын гадаад худалдаанд онцын өөрчлөлт гараагүй бөгөөд ОХУ-ын гадаад худалдааны энэ үеэр буурч байгаа тус улсын экспортын бүтээгдэхүүний эрэлт дэлхийн зах зээл дээр бага байсантай холбоотой болов уу хэмээн дүгнэж байна.


**Зураг 3. SARS –ын үеийн ажилгүйдлийн түвшин (нийт хөдөлмөрийн насны хүмүүсийн тоонд эзлэх хувиар)**



Эх сурвалж: <https://data.worldbank.org/indicator/sl.uem.totl.ne.zs>

Дурдсан хугацаанд Герман, Францад ажилгүйдлийн түвшин бага зэрэг өссөн бол бусад орнуудад энэ үзүүлэлт харьцангуй тогтвортой буюу буурах хандлагатай байжээ. Үүнээс дүгнэхэд SARS өвчин нь эдгээр орнуудын иргэдийн амьжиргаанд төдийлөн хүчтэй нөлөө үзүүлээгүй байна.

*Зураг 4. SARS –ын үеийн гадаадын шууд хөрөнгө оруулалт (ДНБ-нд эзлэх хувиар)*



Эх сурвалж: <https://data.worldbank.org/indicator/bx.klt.dinv.wd.gd.zs>

Харин тус өвчний тархалттай холбоотойгоор БНХАУ, Герман, Испани, Франц, Италид гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ буурсан нь харагдаж байна. Энэ хугацаанд БНХАУ, Хонг Конгийн зах зээлээс хөрөнгө оруулагчид хөрөнгөө татсанаас шалтгаалан их хэмжээний хөрөнгийн урсгал гадагшилж, үүний улмаас үйлдвэрлэлийн хүчин чадлын тогтвортой байдал алдагдан, урт хугацаанд эрэлт, нийлүүлэлтэд сөргөөр нөлөөлснөөр хөрөнгө оруулалтын хэмжээ олон улсад буурахад хүргэжээ.


### **Хоёр. Дэлхийн эдийн засагт 2008-2009 оны санхүүгийн хямралын үзүүлсэн нөлөөлөл**

Дэлхийн санхүү, эдийн засгийн 2008-2009 оны хямрал нь 1929 оны их хямралаас хойш тохиолдсон хамгийн том санхүүгийн хямрал юм. Хэдийгээр АНУ-ын Засгийн газар, Холбооны нөөцийн сангаас энэхүү хямралыг тогтоон барих оролдлогыг хийсэн боловч үр дүнд хүрээгүй бөгөөд үүний үр дүнд АНУ дахь үл хөдлөх хөрөнгийн үнэ хоёр дахин унасан нь их хямралын үеийнхээс ч илүү үзүүлэлт байв.

Энэхүү хямралын сөрөг нөлөөлөл, эдийн засгийн үр дагаврыг нарийн тооцоолоход бэрхшээлтэй боловч 2008-2010 оны хооронд өссөн зардал, буурсан орлогын нийлбэр дүнгээр тооцоход АНУ-ын Засгийн газар 2 их наяд орчим ам.долларын алдагдал хүлээсэн нь 17 жил үргэлжилсэн Афганистаны дайнд зарцуулсан зардлаас 2 дахин их тоо юм. Үүнийг хямралаас өмнөх үеийн АНУ-ын ДНБ-нд эзлэх хувиар тооцож

үзэх юм бол тус улсын ДНБ-ын 15 орчим хувь буюу 2016 оны дүнгээр 4.6 их наяд ам.доллартой тэнцэж байна.[2]


*Зураг 5. Дэлхийн санхүү эдийн засгийн хямралын үеийн ДНБ-ний өсөлтийн хурд*



Эх сурвалж: <https://data.worldbank.org/indicator/ny.gdp.mktp.kd.zg>

Дэлхийн санхүүгийн хямралын үеэр дээр дурдсан улсуудын эдийн засгийн өсөлтийн хурд мэдэгдэхүйц саарсан бөгөөд үүний улмаас Герман 14.4 хувь, Япон 15.2 хувь, Их Британи 7.4 хувь, Европын холбоо 9.8 хувь ДНБ-тэй тэнцэх хэмжээний алдагдал хүлээснийг Дэлхийн банкны тоо мэдээллүүд харуулж байна. Дээрх хүснэгтээс харахад 2008-2010 оны хооронд сонгогдсон орнуудын эдийн засгийн өсөлт мэдэгдэхүйц саарсан байгаа бөгөөд энэ нь Дэлхийн санхүүгийн хямрал улс болгонд сөрөг нөлөөлөө үзүүлснийг баталж байна.


*Зураг 6. Дэлхийн санхүү эдийн засгийн хямралын үеийн инфляцын түвшин*



Эх сурвалж: <https://data.worldbank.org/indicator/ny.gdp.defl.kd.zg>

Дэлхийн санхүүгийн хямралын үеэр инфляцын түвшин бүх орнуудад буурсан үзүүлэлттэй байгаа бөгөөд үүнээс БНХАУ, ОХУ-д инфляцын түвшин огцом буурсан байна. Харин хямралын дараа буюу 2010 онд БНХАУ, ОХУ-ын инфляцын түвшин огцом өсч, Франц, АНУ-д инфляцын түвшин бага зэрэг өсчээ.


**Зураг 7. Дэлхийн санхүү эдийн засгийн хямралын үеийн гадаад худалдааны эргэлт (ДНБ-нд эзлэх хувиар)**



Эх сурвалж: <https://data.worldbank.org/indicator/ne.trd.gnfs.zs>

Хямралын үеэр улс орнуудын гадаад худалдааны эргэлт жигд буурсан үзүүлэлттэй байгаа бөгөөд хямралын дараа буюу 2010 оноос энэ үзүүлэлт дахин өсч эхэлсэн байна. Энэ нь эдийн засгийн хямралын үеэр улс орнуудын гадаад худалдааны эргэлт буурдгийг харуулж байна.


**Зураг 8. Ажилгүйдлийн түвшин (нийт хөдөлмөрийн насны хүмүүсийн тоонд эзлэх хувиар)**



Эх сурвалж: <https://data.worldbank.org/indicator/sl.uem.totl.ne.zs>

Дээрх хүснэгтээс харахад Дэлхийн санхүүгийн хямралын үеэр Испани, Франц, Их Британи, Итали, ОХУ, АНУ-д ажилгүйдлийн түвшин нэмэгдэж байсан бол БНХАУ-д энэ түвшин тогтвортой байж, харин Германд ажилгүйдэл буурчээ. Үүнээс дүгнэхэд эдийн засгийн хямралын үеэр ихэнх орнуудад ажилгүйдлийн түвшин нэмэгддэгийг харуулж байгаа бөгөөд харин Германд энэ түвшин буурсан байгаа нь анхаарал татаж байна.

### *Зураг 9. Гадаадын шууд хөрөнгө оруулалт (ДНБ-нд эзлэх хувиар)*



Эх сурвалж: <https://data.worldbank.org/indicator/sl.uem.totl.ne.zs>

Дэлхийн санхүүгийн хямралын үеэр бүх улсуудын гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ мэдэгдэхүйц буурсан байгаа бөгөөд харин хямралын дараа ихэнх орны хөрөнгө оруулалтын хэмжээ өсөх хандлагатай болжээ. Харин ОХУ, Итали зэрэг орнуудад өсөөгүй байгаа нь тухайн орнуудын хөрөнгө оруулалтын бодлого, орчинтой холбоотой болов уу хэмээн таамаглаж байна.


#### **2.1. Хямралаас гарахад авч хэрэгжүүлсэн арга хэмжээ**

АНУ-ын Засгийн газрын хувьд хямралаас гарахын тулд авч хэрэгжүүлсэн санхүүгийн тусламжийн арга хэмжээнд зарцуулсан 700 тэрбум ам.долларыг татвар төлөгчдийн мөнгөнд халгүйгээр зохион байгуулж чадсан юм. Тус улсын Сангийн яамнаас Эрсдэлд орсон банкны хөрөнгийн хамгаалах хөтөлбөрт зориулж 441.8 тэрбум ам.долларын санхүүжилт хийсэн бөгөөд үүний үр дүнд 442.7 тэрбум ам.доллар тус санд эргэн төвлөрч нийт 900 сая ам.долларын ашигтай ажилласан байна. Үүнийг АНУ-ын Засгийн газраас эрсдэлд орсон компаниудын хувьцааг хямд үед нь худалдан авч, үнэтэй үед нь зарах замаар гүйцэтгэсэн байна.[3]



### Зураг 10. Дэлхийн санхүүгийн хямралын үзүүлсэн санхүүгийн нөлөөлөл

Дэлхийн санхүүгийн хямралын үзүүлсэн санхүүгийн нөлөөлөл



Эрсдэлд орсон банкны хөрөнгийн хамгаалах хөтөлбөр нь дараах 5 салбарт дэмжлэг үзүүлж чадсан. Үүнд:

- Банкны давуу эрхийн 245.1 тэрбум ам.долларын үнэ бүхий хувьцаа худалдан авах замаар тэдгээр банкуудад бэлэн мөнгөний дэмжлэг үзүүлсэн;
- Авто машин үйлдвэрлэгч компаниудад 79.7 тэрбум ам.долларын дэмжлэг үзүүлсэн;
- American International Group (AIG) компанид үзүүлсэн 182 тэрбум ам.долларын зарим хэсгийг санхүүжүүлэхэд 67.8 тэрбум ам.доллар зарцуулсан;
- Банкны зээлийг өргөжүүлэхэд зориулж 19.1 тэрбум ам.долларын санхүүжилт хийсэн бөгөөд үүнийг банкууд 23.6 хувиар өсгөж, Засгийн газар 4.5 тэрбум ам.долларын ашигтай ажилласан;
- Өрхийн худалдан авах чадварыг дэмжих, ипотекийн зээлийн нөхцөлийг өөрчлөхөд зориулж 30.1 тэрбум ам.долларын санхүүжилт хийсэн байна.

Үүнээс гадна Ерөнхийлөгч Барак Обама эрсдэлд орсон банкны хөрөнгийн хамгаалах хөтөлбөрт хуримтлагдсан 700 тэрбум ам.долларын үлдэгдлийг бусад бизнес аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг тогтворжуулахад дэмжлэг болгон өгөхөөс татгалзсан бөгөөд үүний оронд эдийн засгийг дэмжих хөтөлбөрийг дэмжихийг Конгрессоос хүссэн. Энэхүү төлөвлөгөөг Конгресс дэмжсэнээр 2009 оны 2 дугаар сарын 17-ны өдөр тэрээр АНУ-ын эдийн засгийг сэргээх, дахин хөрөнгө оруулалт хийх хууль (American Recovery and Reinvestment Act)-д гарын үсэг зурсан бөгөөд энэхүү хуулийн хүрээнд татварыг бууруулж, төрийн худалдан авах ажиллагааны зардлыг нэмэгдүүлсэн байна.


Ингэснээр 2011 он гэхэд АНУ-ын жижиг, дунд бизнес эрхлэгчдэд 831 тэрбум ам.долларын шууд хөрөнгө оруулалт хийгдэж улмаар Дэлхийн санхүүгийн хямрал албан ёсоор төгссөн гэж тооцдог.

### Гурав. Дэлхийн эдийн засагт COVID-19-ийн үзүүлсэн нөлөөллийг харьцуулах нь

COVID-19-ийн халдвар оргил үедээ хүрч, дэлхийн ихэнх орнуудад хөл хорио тогтоосонтой холбогдуулан ОУВС-гаас эрхлэн гаргадаг эдийн засгийн төлөв байдлын судалгаагаар дэлхийн ДНБ-ын өсөлтийг таамаглалыг -3 хувь болгон бууруулав. Энэ нь 2020 оны 1 дүгээр сард төсөөлж байсан өсөлтөөс 6.3 хувиар доогуур үзүүлэлт бөгөөд маш богино хугацаанд өсөлтийг ийнхүү анх огцом бууруулсан тохиолдол болов. Ингэснээр COVID-19-өөс улбаатай хөл хорионы улмаас үүсэн эдийн засгийн хямрал нь эх уналтаас хойших хамгийн том эдийн засгийн хямрал болох нь ойлгомжтой болов. Түүнтэй харьцуулахад 2009 оны Дэлхийн санхүүгийн хямралын хохирол өчүүхэн бага юм.

#### *Зураг 11. Дэлхийн санхүүгийн хямрал 2009-ыг COVID-19 тэй харьцуулсан Дэлхийн ДНБ-ний өсөлтийн хэмжээ.*

Цэвэр ДНБ-ны өсөл, жилийн харьцуулалт




Эх сурвалж: ОУВС, Дэлхийн эдийн засгийн төлөв байдлын судалгаа

Энэхүү халдварт өвчний тархалтыг 2020 оны хоёрдугаар хагаст амжилттай тогтоон барьж, улс орнуудын Засгийн газрууд аж ахуйн нэгжийг дампуурах, ажилгүйдлийг бууруулах, олон улсын санхүүгийн тогтолцооны үйл ажиллагааг хэвийн хадгалах арга хэмжээг сайн авч хэрэгжүүлж чадна гэж үзвэл 2021 онд дэлхийн эдийн засаг 5.8 хувиар өсөх боломжтой хэмээн тус байгууллагаас тооцоолсон байна. Тус төлөв нь коронавирус дэлхийн эдийн засагт нөлөөлж эхлэхээс өмнөх үеийн тооцоолол дээр суурилсан учраас 2021 оны эдийн засгийн өсөлтийн хэмжээ нь бага байх бөгөөд энэ дүн нь ойролцоогоор 9 их наяд ам.доллар буюу дэлхийн 3, 4 дэх том эдийн засаг болох Япон, Германыг нийлүүлсэнтэй тэнцэх ажээ.

## Зураг 12. Дэлхийн эдийн засгийн өсөлт 2018-2021

Дэлхийн ДНБ-ны өсөлт




Эх сурвалж: ОУВС, Дэлхийн эдийн засгийн төлөв байдлын судалгаа

Их хөл хорионы улмаас бий болсон нөхцөл байдал нь аялал жуулчлал, тээвэр, зочид буудал, энтертаймангийн салбарын өсөлтөд хамгийн их сөрөг нөлөөллийг үзүүлж байна. Түүнээс гадна энэхүү хямрал нь хөгжиж байгаа орнуудад сул хөгжилтэй эрүүл мэндийн салбараа багахан боломж дээрээ тулгуурлан тэтгэхээс гадна хөрөнгийн урсгал тасрах, валютын дарамт үүсэх зэрэг урьдчилан төлөвлөх боломжгүй сорилтуудыг бий болгоод байна.

## Зураг 13. Дэлхийн эдийн засгийн өсөлт 2009 ба 2020

Дэлхийн ДНБ-ын өсөлт, жилээр



Эх сурвалж: ОУВС, Дэлхийн эдийн засгийн төлөв байдлын судалгаа

Коронавирусаас үүдэлтэй хямралын нөлөөгөөр өндөр хөгжилтэй болон хөгжиж буй орнууд хамтдаа энэхүү эдийн засгийн хүндрэлтэй нүүр тулж байгаа нь Их уналтаас хойш гарч буй анхны тохиолдол юм. Энэ жилийн хувьд өндөр хөгжилтэй орнуудын эдийн засгийн өсөлт -6.1 хувь байх бол хөгжиж байгаа орнуудын эдийн засгийн өсөлт -1 хувь орчим байх төлөвтэй байгаа бөгөөд нийт 170 орны нэг хүнд ногдох ДНБ-ны хэмжээ буурах төлөвтэй байна. Гэвч нөхцөл байдал ойрын хугацаанд сайжирч чадвал өндөр хөгжилтэй, хөгжиж байгаа орнуудын аль аль нь 2021 онд эдийн засгаа сэргээж чадна гэсэн төсөөлөлтэй байна гэж ОУВС-ын Дэлхийн эдийн засгийн төлөв байдлын судалгаанд дурджээ. [4]

*Хүснэгт 1. Дэлхийн эдийн засгийн өсөлтийн төлөв байдал*

<b>Төсөөлөл</b>			
<b>ДНБ-ны жилийн өсөлт</b>	<b>2019</b>	<b>2020</b>	<b>2021</b>
<b>Дэлхий</b>	<b>2.9</b>	<b>-3.0</b>	<b>5.8</b>
Өндөр хөгжилтэй эдийн засгууд	1.7	-6.1	4.5
АНУ	2.3	-5.9	4.7
Европын холбоо	1.2	-7.5	4.7
Герман	0.6	-7.0	5.2
Франц	1.3	-7.2	4.5
Итали	0.3	-9.1	4.8
Испани	2.0	-8.0	4.3
Япон	0.7	-6.5	4.0
Их Британи	1.4	-6.5	4.0
Канад	1.6	-4.6	4.5
Бусад өндөр хөгжилтэй орнууд	1.7	-4.6	4.5
Хөгжиж байгаа орнууд	3.7	-1.0	6.6
Азийн хөгжиж байгаа орнууд	5.5	1.0	8.5
Хятад	6.1	1.2	9.2
Энэтхэг	4.2	1.9	7.4
АСЕАН	4.8	-0.6	7.8
Европын хөгжиж байгаа орнууд	2.1	-5.2	4.2
Орос	1.3	-5.5	3.5
Латин Америк	0.1	-5.2	3.4
Бразил	1.1	-5.3	2.9
Мексик	-0.1	-6.6	3.0
Ойрхи Дорнод	1.2	-2.8	4.0
Саудын Араб	0.3	-2.3	2.9
Сахараас өмнөх Африк	3.1	-1.6	4.1
Нигери	2.2	-3.4	2.4
Өмнөд Африк	0.2	-5.8	4.0

Эх сурвалж: ОУВС, Дэлхийн эдийн засгийн төлөв байдлын судалгаа

**3.1. Дэлхийн эдийн засагт COVID-19-ийн үзүүлсэн нөлөөллийн бууруулах чиглэлээр дэлхийн улс орнууд авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ:**

**3.1.1. Америкийн Нэгдсэн Улс**

АНУ-ын Ерөнхийлөгч Д.Трамп эдийн засгийн хямралтай тэмцэхэд зориулж 2 их наяд ам.долларын багц гаргах тухай хуулийн төслийг 3 дугаар сарын 27-ны өдөр гарын үсэг зурав. Уг хуулийн төсөл хэрэгжиж эхэлснээр АНУ-ын насанд

хүрсэн иргэн бүрт 1,200 ам.доллар, хүүхэд бүрт 500 ам.долларын нэг удаагийн тусламж, аж ахуйн нэгж болон муж хотуудад 500 тэрбум ам.долларын зээл болон зээлийн баталгаа гаргахад /үүнээс 425 ам.доллар нь бизнес эрхлэгчдэд, 50 тэрбум ам.доллар нь агаарын тээврийн компаниудад, 8 тэрбум ам.доллар нь карго, ачаа тээврийн салбарт, 17 тэрбум ам.доллар нь үндэсний аюулгүй байдалтай холбоотой арга хэмжээнд/, цалин тавихад хүндрэл үүссэн, 500 хүртэл ажилтантай, жижиг дунд бизнес эрхлэгчдэд 367 тэрбум ам.долларын санхүүжилт олгох, эмнэлгүүдэд 150 тэрбум ам.долларын санхүүжилт олгох, ажилгүйдлийн даатгалын сард олгох үнийн дүнг 4 сарын турш 600 ам.доллараар нэмэгдүүлэх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. [5]

Түүнчлэн АНУ-ын Холбооны нөөцийн банк 3 дугаар сарын 3-ны өдөр ээлжит бус хурлаар бодлогын хүүг 1-1.25% болгон 0.5%-иар бууруулаад байсан бол 3 дугаар сарын 15-ны өдөр бодлогын хүүг “0” хувь болгон бууруулж, зах зээлд 700 тэрбум ам.доллар /үүнээс 500 тэрбум ам.доллар нь Засгийн газрын бонд худалдан авахад, үлдэх 200 тэрбум ам.доллар нь ипотек буюу үл хөдлөх хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг худалдан авах зорилготой/-ыг мөнгөний бодлогоор дамжуулан зах зээлд нийлүүлэхээр болсон. Бодлогын хүүг бууруулах нь эдийн засагт мөнгөний зөөлөн бодлогын дагуу түлхэц өгч, компаниудыг хөрөнгө оруулах, зээл авах нөхцөлийг сайжруулах зорилготой юм. [6]

Мөн тус улсын Засгийн газрын зүгээс United, American, Delta зэрэг томоохон агаарын тээврийн компаниудын үйл ажиллагааг хэвийн болгоход зориулж 25 тэрбум ам.долларын санхүүгийн дэмжлэгийг олгохоор шийдвэрлэсэн бөгөөд олон улсын агаарын тээврийн байгууллага (IATA)-ын тооцоолсноор дэлхийн агаарын тээврийн компаниуд нийт 314 тэрбум ам.долларын алдагдал хүлээгээд байгаа ажээ. [7]

### 3.1.2. Бүгд Найрамдах Хятад Ард Улс

Хятадын Хөдөө аж ахуйн хөгжлийн банк аж ахуйн нэгжүүд, ялангуяа жижиг, дунд аж ахуйн нэгжүүдэд шинээр зээл олгох, зээлийн эргэн төлөлтийн хугацааг сунгах, өөрчлөлт оруулах зорилгоор 137 тэрбум юанийг төсөвлөсөн байна. Тус банкнаас 252 жижиг болон бичил аж ахуйн нэгжийн зээлийн төлөх хугацааг хойшлуулж, 489 аж ахуйн нэгжийн зээлийн төлөлтийн төлөвлөгөөг шинэчилж, 6,27 тэрбум юанийн зээлийг шинэчилж, COVID-19-тэй тэмцэх үйл ажиллагаанд оролцож буй аж ахуйн нэгжүүдэд 53,5 тэрбум юанийн яаралтай тусламжийн зээл олгожээ.

Мөн COVID-19 өвчний улмаас үйл ажиллагаа нь зогссон үйлдвэрлэлийг сэргээхэд зориулж Хятадын банк, санхүүгийн салбараас нийт 1.4 их наяд гаруй юанийн зээлийн дэмжлэгийг холбогдох аж ахуйн нэгжүүдэд үзүүлээд байгаа бөгөөд хямралд өртсөн Хубэй мужийн жижиг дунд үйлдвэрлэгчдийг НӨАТ-аас чөлөөлөх, хугацаа хэтэрсэн зээлд алданги тооцохгүй байх, хөрөнгө оруулагчдыг татах үүднээс Засгийн газраас авч хэрэгжүүлж буй бүх арга хэмжээнд гадаадын хөрөнгө оруулалттай компаниудыг ижил тэгш нөхцөлөөр хамрагдах боломжийг нээж өгөхөөр шийдвэрлэсэн байна. [8]

### 3.1.3. Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

Эдийн засгийн хүндрэлийн улмаас ажилчдын 10% нь сул зогсоход хүрсэн аж ахуйн нэгж сул зогсолтын нөхөн олговор олгох шийдвэрийг гаргаснаас гадна хөл хорионы улмаас үйл ажиллагаа нь доголдсон аж ахуйн нэгжүүдийн татвар төлөх хугацааг хойшлуулах, татвараа хугацаанд нь төлөөгүй компаниудын дансыг хаах, торгууль ногдуулах арга хэмжээг 2020 оны 12 дугаар сарын 31 хүртэл хэрэглэхгүй байх шийдвэрийг гаргажээ.

Түүнчлэн Холбооны Засгийн газраас аж ахуйн нэгжүүдийн зээлд төрийн баталгаа гаргахад 400 тэрбум евро, төрийн хөрөнгө оруулалтыг дэмжихэд 100 тэрбум евро, “Эдийн засгийн тогтворжилтын сан”-д зориулж 100 тэрбум еврогийн санхүүжилт хийхээр болоод байна. [9]

### 3.1.4. Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс

Тус улсын Засгийн газраас бүх төрлийн аж ахуй нэгжүүдэд үзүүлэх дэмжлэгийг нэмэгдүүлэх хүрээнд нийт 330 тэрбум фунт стерлингийн дүн бүхий баталгааг дотоодын аж ахуй нэгжүүддээ арилжааны түвшнээс бага хүүтэй зээл авах нөхцөлийг бүрдүүлж өгөхөд зориулан гаргахаар шийдвэрлээд байна. Үүнээс гадна 51,000 фунт стерлингээс доош орлоготой жижиглэнгийн худалдаа, зочид буудал болон амралт сувиллын салбарт үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүдийг үл хөдлөх хөрөнгийн албан татвараас 1 жилийн хугацаанд бүрэн чөлөөлөх, мөн тэдгээр бизнес эрхлэгчдэд татварын хөнгөлөлт үзүүлэхээс гадна нэмж 25,000 хүртэлх фунт стерлингийн буцалтгүй тусламж олгохоор шийдвэрлэсэн байна.[10]

## Доргов. ДҮГНЭЛТ

Энэхүү судалгааны ажлын эцэст дараахь дүгнэлтүүдийг хийхэд хүрлээ. Үүнд;

- Дэлхийн эдийн засагт SARS-ийн үзүүлсэн нөлөөлөл харьцангуй бага бөгөөд зөвхөн БНХАУ, Хонг Конг, Сингапурын эдийн засагт бага хэмжээгээр нөлөөлсөн байна. SARS өвчний улмаас харьцангуй цөөн хүний амь нас үрэгдэж, эдийн засагт харьцангуй бага хэмжээний хохирол учирсан боловч энэ нь халдварт өвчний улмаас дэлхий хэмжээний эдийн засгийн хямрал гарах боломжтой гэдгийг улс орнуудад дахин баталсан үйл явдал болсон байна.
- SARS өвчний үеэр эдийн засаг нь хэвийн байсан орнуудын ДНБ-ны өсөлт өвчний дараагийн жилээс эхлэн саарч байгаа нь эдийн засгийн их бага, хэмжээний хямралын нөлөө дахин дам хэлбэрээр илэрэх магадлал байгааг харуулж байна.
- Дэлхийн санхүүгийн хямралын үеэр инфляцын түвшин бүх орнуудад буурсан үзүүлэлттэй бөгөөд харин хямралын дарааинфляцынтүвшин эргэж өсөх хандлагатай байдаг нь ажиглагдав.
- Дэлхийн санхүүгийн хямралын үеэр ажилгүйдлийн түвшин нэмэгдэж, санхүүгийн хямрал дууссаны дараа ажилгүйдлийн түвшин эргэж буурдаг хандлагатай байна.
- COVID-19-өөс үүдэлтэй эдийн засгийн хямралхэзээ дуусахыг төрийн бодлого, санхүүгийн арга хэрэгслээс илүү биологи түүний дотор тус өвчний эрсэг үр дүнтэй вакцин хэзээ гарч, дэлхий нийтийн хэрэглээ болохоос бүрэн хамаарахаар байна. Энэ шалтгаанаар тус хямралын үргэлжлэх хугацаа, учруулах хор хохирлыг урьдчилан тооцоолох боломжгүй байна.
- COVID-19-өөс үүдэлтэй эдийн засгийн хямралыг даван туулахад Засгийн газруудын үүрэг оролцоо, бодлого чухал бөгөөд хамтын хүчин чармайлт хэрэгтэй байна. Ялангуяа их гүрнүүд өвчний вакциныг нээх, хөгжиж буй орнуудын эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр хамтран ажиллах шаардлагатай байна.
- Улс орнууд COVID-19 өвчний тархалтыг 2020 оны эхний хагас жилд амжилттай тогтоон барьж чадсан ч түүнээс үүдэлтэй эдийн засгийн хямралыг 2022 он хүртэл бүрэн арилгах боломжгүй байна.
- Дэлхийн өндөр хөгжилтэй улс орнууд COVID-19 өвчний эдийн засагт үзүүлэх нөлөөлөлийг бууруулах зорилгоор Мөнгөний бодлого гэхээс илүүтэй Төсвийн бодлогыг түлхүүтэй авч хэрэглэх, төсөв, мөнгөний бодлогыг хослуулах, бодлогын гол зорилго нь иргэний орлогыг хамгаалах, аж ахуйн нэгжийн бизнесийг хамгаалах, эрүүл мэндийн салбарыг сайжруулах тал руугаа бодлогоо хэрэгжүүлж байна.

## Тав. ЗӨВЛӨМЖ

Азийн Хөгжлийн Банкны 2020 тайланд тусгаснаар тус банк Монгол Улсын 2020 оны эдийн засгийн өсөлтийг 2019 оны гүйцэтгэл 5.1%-иас мэдэгдэхүйц буурч 2.1%, 2021 онд 4.6% байхаар төсөөлсөн байна. Эдийн засгийн нөхцөл байдлыг төсөөлснөөс ч муутгаж болзошгүй эрсдэлүүд байсаар байгаа бөгөөд тухайлбал, COVID-19 цар тахал улам ужгиран гүнзгийрч, нөлөөлөл нь илүү удаан хугацаанд үргэлжлэх тохиолдолд 2020 оны эдийн засгийн өсөлт төсөөлснөөс буурах, ажилгүйдэл огцом нэмэгдэх, төлбөрийн тэнцэл, улсын төсөвт үлэмж хэмжээний дарамт учруулах, эдийн засгийн өндөр эрсдэлийн улмаас гадаадын хөрөнгө оруулагчид, зээлдүүлэгчдийн Монгол Улсад хөрөнгө оруулалт хийх, зээл өгөх сонирхол эрс багасах, банкны салбарт хөрвөх чадварын эрсдэл бий болох зэрэг сөрөг үр дагавар үүсч болзошгүй байна. [11]

COVID-19 цар тахалтай холбогдуулан МҮХАҮТ-аас гаргасан судалгаанд дурдсанаар манай улс хилийн хоригоос үүдэн нүүрсний экспортоос олохоор төлөвлөсөн 400 гаруй сая ам.долларыг одоогоор алдаад байгаа ажээ. Тус хугацаанд аж ахуйн нэгж болон иргэдийн орлого, зээлийн эргэн төлөлт тасрахэрсдэл үүсэж байгаа бөгөөд вирусийн нөлөөнд хамгийн түрүүнд өртөх салбарууд нь ДНБ-ний 44 хувь, ажиллах хүчний 35 хувь, зээлийн 27 хувийг тус тус бий болгож байна гэжээ. [12]

Иймээс COVID-19 цар тахалтай холбоотойгоор үүссэн эдийн засгийн хүндрэлийг даван туулахын тулд Засгийн газраас дараах бодлого, арга хэмжээг авч яаралтай авч хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж байна. Үүнд:

- Төсөвт тодотгол хийж, шаардлагагүй, тэвчиж болох зардлуудыг танах;
- Халамжийг хавтгайруулан олгох байдлыг зогсоож, хэмнэгдсэн хөрөнгийг нийгмийн эмзэг хэсгийн хүнсний нэмэгдүүлэх, эрүүл мэндийн салбарын чадамжийг нэмэгдүүлэхэд зарцуулах;
- Арилжааны банкны зээлийн нөхцөлийг уян хатан болгох, төлбөр төлөх хугацааг хойшлуулж, энэ хугацаанд торгууль ногдуулахгүй байх;
- ЖДҮ эрхлэгчдэд татварын хөнгөлөлт үзүүлэх, зөвхөн энэ салбарт ажиллагсдыг орлогын татвар болон НДШ-ээс тодорхой хугацаагаар чөлөөлөх;
- Аялал жуулчлалын салбар дахь аж ахуйн нэгж, тухайлбал иргэний нисэх, зочид буудал, амралтын газруудын урсгал зардлыг төрөөс хариуцах;
- Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүнүүдийн нийлүүлэлтийг тогтвортой хангах, газар тариалан, хүнсний үйлдвэрлэл эрхлэгчдэд дэмжлэг үзүүлэх замаар хүнсний хэрэгцээгээ дотоодоосоо бүрэн хангах боломжийг бүрдүүлэх зэрэг болно.



**Ашигласан материал**

- [1] Jong-Wha Lee, Warwick J. McKibbin (2004) “ESTIMATING THE GLOBAL ECONOMIC COSTS OF SARS”
- [2]Gautam Mukunda (2008), The Social and Political Costs of the Financial Crisis, 10 Years Later
- [3]KIMBERLY AMADEO, SOMER G. ANDERSON, 2008 financial crisis, causes, costs and whether it could happen again
- [4] GITA GOPINATH, the Great Lockdown: Worst Economic Downturn since the Great Depression
- [5] ERICA WERNER, PAUL KANE AND MIKE BEBONIS, Trump signs \$2 trillion coronavirus bill into law as companies and households brace for more economic pain, Washington Post, March 28, 2020
- [6] FEDERAL RESERVE ISSUES FOMC STATEMENT, Release of March 15, 2020
- [7] DOMINIC RUSHE, US government agrees on \$25bn bailout for airlines as pandemic halts travel, The Guardian
- [8] ZOEY ZHANG, China’s Support Policies for Business under COVID-19: A Comprehensive List
- [9] KATIE HICKS, WINFRIED M.CARLI, ELIZAVETA BAZAROVA, MARIUS GARNATZ, Availability of Government support for infrastructure businesses
- [10] Release of the HM Treasury, How to access government financial support if you or your business has been affected by COVID-19
- [11] Азийн хөгжлийн банк: МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ 2020 ОНД COVID-19 ЦАР ТАХЛЫН УЛМААС ОГЦОМ БУУРАХ ТӨСӨӨЛӨЛТЭЙ БАЙНА
- [12] МҮХАҮТ: Эдийн засгийн эрсдлийн удирдах багц санал